



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/325

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, 33.3.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 24 дүгээрр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.4, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2 дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Паралимпийн суугаа волейболын 20 дахь удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 2,758,400 (хоёр сая долоон зуун тавин найман мянга дөрвөн зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 31-ны өдрийн 135 дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Явах чиглэл	Нэг хүний зардал	Явах хүний тоо	Нийт зардал
1.	Говь-Алтай аймгаас Улаанбаатар хот хүртэл	78200	16	1,251,200
2.	Улаанбаатар хотоос Говь-Алтай аймаг хүртэл	78200	16	1,251,200
3.	Улаанбаатар хотоос Зүүнхараа хүртэл	8000	16	128,000
4.	Зүүнхараагаас Улаанбаатар хот хүртэл	8000	16	128,000
	Нийт зардал			2,758,400

__оОо__

